



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2023.03.09. № 01/3804
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН АЛБАНЫ ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Г.БАТЗОРИГ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газар нь авлигын гэмт хэргийг шалгахгаас гадна авлигын гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг тогтоох, цаашид гарахгүй байх таслан зогсоох бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх хүрээнд авлигаас ангид байлгах, авлигын гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгжүүдэд түргэн шуурхай, ил тод, хүнд суртал чирэгдэлгүй хүргэх, нийтийн албан тушаалтны ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр ажилладаг. Энэ ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр баталсан Удирдамж, төлөвлөгөөний дагуу Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2021 онд өгсөн Авлигын эрсдэлийн үнэлгээ, Зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнг тооцох чиглэлээр зөвлөмжийн хэрэгжилтийн байдалтай танилцан ажиллав.

Ажиллах явцад Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд гарч буй хүндрэл бэрхшээл нь өгөгдсөн зөвлөмжийн 11, 13 дахь хүрээнд хангалтгүй хэрэгжүүлсэн, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бүрдэх эрсдэлийг бий болгохоор байна.

Цаашид хүнд суртал, албан тушаалтнуудын ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байх чиглэлээр албан зөвлөмжийг Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасны дагуу хүргүүлж байна.

Зөвлөмжийн мөрөөр холбогдох арга хэмжээг авч, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасны дагуу биелэлт, үр дүнгийн талаар 2023 оны 03 дугаар сарын 31-ний дотор хариу ирүүлнэ үү.

Хувийг: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР



З.ДАШДАВАА

142303003957

Авлигатай тэмцэх газрын
2023 оны 03 дугаар сарын 3-ны өдрийн
... дугаар албан бичгийн хавсралт

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ЗӨВЛӨМЖ

Зөвлөмж 1. Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаа, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт холбогдох хууль, дүрэм, журмын дагуу шийдвэрлэгдэж байгаа эсэхэд хяналт тавих, ажлын гүйцэтгэлийн үр дүнг сайжруулах, хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцох;

Өргөдөл, гомдол тэдгээрийн шийдвэрлэлтийн 2021, 2022 оны үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж хариуцлага алдсан нэр бүхий албан хаагч нарт сахилгын шийтгэл ногдуулсан боловч Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны нэр бүхий албан хаагч нарт “авлига өгөх”, “бусдаас авлига аваад газрын наймаа хийдэг”, “надаас авлига хараад байна” гэх утгатай 5 гомдлыг нэр бүхий иргэдээс гаргасныг хүлээн авч хуулийн дагуу шийдвэрлэлгүй хаасан зэрэг зөрчил гаргасан байна.

Тус газар нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад газартай холбоотой үзүүлж байгаа төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдэл, албан хаагчийн ёс зүйн зөрчил, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй өргөдөл, гомдол, хүсэлтийг зохих хуулийн дагуу оновчтой бүрэн шийдвэрлэдэггүй нь Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т зааснаар “Төрийн бүх шатны байгууллагын албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэж байх явцдаа олж мэдсэн авлигатай холбоотой асуудлыг шалгаж шийдвэрлэх нь өөрийнх нь бүрэн эрхэд хамаарахгүй байвал Авлигатай тэмцэх газарт мэдээлнэ” гэснийг хэрэгжүүлдэггүй нөхцөл байдлууд илэрсэн.

Мөн иргэдээс нэр бүхий албан хаагч нарын ёс зүй, төрийн үйлчилгээний хүнд сурталтай холбоотой гомдлыг удаа дараа гаргасан байхад гомдлыг “Ёс зүйн зөвлөл”-өөр ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг шалгаж шийдвэрлэлгүй орхигдуулдаг, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр ямар нэгэн арга хэмжээ авдаггүй байна.

Зөвлөмж 2. Байгууллагын үйл ажиллагаандаа хүчин төгөлдөр бус дүрэм, журмыг даган мөрдөх, хуулиар олгогдоогүй эрхийг хэрэгжүүлэхгүй байх;

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 5/14 дугаартай тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт барилга барих газрын эрх олгох, барилгын эх загвар зураг батлах, барилга угсралтын ажил эхлүүлэх, ашиглалтад оруулах үйл ажиллагааны журам”, хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх, хугацааг сунгах, газрын зориулалтыг өөрчлөх үйл ажиллагааны журам”-ыг тус тус хянан үзэхэд дээрх журмын зарим үйл ажиллагааг зохицуулсан заалтуудыг үндэслэсэн тогтоол, тушаал, шийдвэр нь хүчин төгөлдөр бус болсон байхад байгууллагын үйл ажиллагаандаа мөрдөж байгаа нь авлигын гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг бий болгож байна.

Салбарын хэмжээнд дагаж мөрдөж буй дүрэм, журам, тушаал шийдвэрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт

оруулах, шинэчлэн боловсруулсан төслийг батлах эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх арга хэмжээг авдаггүй байна.

Зөвлөмж 3. Өргөдөл, гомдол, хүсэлтийн хуваарилалт, тэдгээрийн шийдвэрлэлтийн байдалд хяналт тавих, албан хаагчдын сахилга, бат, ёс зүй, ур чадварыг дээшлүүлэхэд нэгжийн удирдлага хангалттай хэмжээнд ажиллаагүй байх тул хариуцлага тооцох, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр бодитой арга хэмжээ авах;

Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд нийт 2021 онд 1889 өргөдөл гомдол ирснээс хугацаа хэтэрсэн 84, 2022 онд 3287 өргөдөл, гомдол ирсэнээс шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоногоор, хугацаа хэтрүүлэн шийдвэрлэлт 4.6 дахин багассан хэдий ч уг зөрчил арилахгүй байсаар байна.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системд өргөдөл, гомдол, хүсэлт ирэхэд удирдлагын заалт идэвхигүй, шийдвэрлэлтийн байдал бүрэн бус, (нэгж)-ийн удирдлага албан хаагч нарт арга зүйн удирдлагаар хангадаггүй, шийдвэрлэлтэнд хяналт тавих нөхцөл бүрдээгүй байна. Мөн өргөдөл, гомдол, хүсэлтийн хуваарилалтыг тойргийн зарчимд шилжүүлэн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь зүйтэй байна.

Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд нэр бүхий иргэдээс албан хаагч нарын ёс зүй, хүнд сурталтай холбоотой 2020 онд 22, 2021 онд 24, 2022 онд 63 өргөдөл, гомдол гаргасан байгаа нь байгууллагын нэр хүнд, албан хаагчдын сахилга бат муу, хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ бүрэн биелүүлэхгүй байна гэх үнэлгээг олон нийтийн зүгээс өгөх боломж бүрдсэн байна.

Байгууллагын дотоод соёл, албан хаагчдын хандлага, ёс зүй, ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр дотоод зохион байгуулалтын арга хэмжээг авах, албан хаагчдыг үе шаттай сургалтад хамруулах шаардлагатай.

---oOo---